



2023 оны 6-р сарын 22
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
И-мэйл: communications@amcham.mn
Утас: +976 99091557
Вэб: <https://amcham.mn/publications/1>

Хэвлэлийн мэдээ

АмЧам Монгол “Цахим эдийн засгийн бүсийн чуулга” хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2023 оны 6-р сарын 20-ний өдөр “Цахим эдийн засгийн бүсийн чуулга” хэлэлцүүлгийг Шангри-Ла Улаанбаатарт амжилттай зохион байгуулав.

Уг хэлэлцүүлэгт АНУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ричард Буанган, Монгол улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Сайдын зөвлөх С. Тэнгис, түүнчлэн Ази-номхон далайн бүсийн Америкийн худалдааны танхимуудын төлөөлөл, тухайлбал, АмЧам Камбож, АмЧам Мьянмар, АмЧам Лаос, АмЧам Индонези зэрэг байгууллагуудын бодлого хариуцсан мэргэжилтнүүд онлайнгаар болон биеэр хүрэлцэн ирж оролцлоо.

Нээлтийн үгэндээ Элчин сайд Ричард Буанган онцлохдоо “Цахим ертөнцийн бүх боломжуудыг ашиглахын тулд бизнес эрхлэгчид болон засгийн газрууд хувь хүний болон эдийн засгийн эрх чөлөөг хариуцлагатайгаар хамгаалахын зэрэгцээ цахим орчныг төлөвшүүлэхийн тулд бие биетэйгээ зөвшилцөн бодлого боловсруулах хэрэгтэй. Ямар ч орчинд Засгийн газар болон олон нийт гэмт хэргийн үйлдлүүдээс хамгаалагдах эрхтэй, Монгол



Улсын хууль тогтоомжид үүнийг боломжийн сайн зохицуулсан байдаг. Харин улс төрийн яриа, худалдааны яриа хоёр хоорондоо маш нягт холбоотой тул нэгийг нь золиосолж, нөгөөг нь буулгаж болохгүй” гэж хэлэв.

Цахим Эдийн Засгийн Бүсийн Форум нь “Цахим бодлогын сорилт ба боломжууд: хууль эрх зүйн орчин, нийгмийн сүлжээ, кибер аюулгүй байдал”, “Шинээр гарч ирж буй технологиудын талаархи бодлого, зохицуулалт” гэсэн үндсэн хоёр сэдвээр панел хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд олон нийтийн сүлжээнд хүний үг, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахгүйгээр хэрхэн интернэтийн орчинд гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, бага болон өсвөр насны хүүхдийг болзошгүй эрсдлээс хамгаалах, эдийн засгийн ашиг сонирхлын сэдэлтэй залилан зэрэг гэмт үйлдлээс сэргийлэх, тэдний эрхийг хамгаалах талаар санал бодлоо хуваалцаж, олон улсын сайн туршлагуудаас хуваалцав.



Цахим орчны зохицуулалт, нийгмийн сүлжээний хууль эрх зүйн талаар онцлох танилцуулга хийсэн Камбож дахь Парагон Их Сургуулийн Дэд-ректор Брэдли Женсэн Мург хэлэхдээ “Сошиал медиаг хамтран зохицуулах нь дэлхийн тэргүүлэх туршлага болж байна. Засгийн газар хувийн хэвшил болон бүх оролцогч талуудтай идэвхтэй хамтран ажиллах, мөн дижитал засаглалын харилцаа холбооны сувгуудыг институци болгох нь энэ чиглэлийн бодлогыг урагшлуулахад нэн чухал юм.” гэж тайлбарлав.



Мөн түүнчлэн “Технологийн салбарын шинэ трендүүд” сэдвээр Дижитал маркетинг, зөвлөх үйлчилгээ эрхлэгч Манго Танго Ази компанийн Гүйцэтгэх захирал Кристофер МакКарти танилцуулга хийж, зочдын асуултаудад хариуллаа.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.